

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар: 05

Улаанбаатар хот

**Бодлогын баримт бичиг
батлах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.4.2.6.ж, 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Залгамж халааны бодлогын баримт бичиг”-ийн хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (З.Энхболд)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ



ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үндэсний давхар даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн удирдах албан тушаалтны орон тоонд гэнэтийн өөрчлөлт орсноос үл хамаарч компанийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явагдах нөхцөлийг хангахын тулд Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гишүүн болон компанийн бусад эрх бүхий албан тушаалтны залгамж халааг энэ баримт бичгээр тодорхойлно.

1.2. Энэ баримт бичиг нь компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо (цаашид “Хороо” гэх) нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшүүлэх ажилтны ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх ба үнэлж, дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлнэ.

2.2. Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд Хороо болон компанийн гүйцэтгэх захирал жил бүр хүний нөөцийн судалгаа хийнэ.

2.3. Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтооно. Хороо нь компанийн хүний нөөцөөс болон гаднаас эрх бүхий албан тушаалд тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, томилох эрх бүхий этгээдэд санал болгоно.

2.4. Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг томилох эрх бүхий этгээдэд гаргана.

2.5. Хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг үнэлж, дүгнэхдээ “ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх журам”-ыг баримтална.

Гурав. Бусад зүйл

3.1. Хороо нь энэ баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавина.

3.2. Энэ баримт бичгийг холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг компани хариуцна.

3.3. Компани энэ баримт бичигт тусгагдаагүй компанийн эрх бүхий албан тушаалтны залгамж халаатай холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

3.4. Компанийн гүйцэтгэх захирал энэ баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.5. Энэ баримт бичгийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.